



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/151/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг: bolor-erdened@audit.gov.mn
Аудитор: Д.Эрдэнэчимэг
Утас: 260512 Цахим хаяг: erdenechimegda@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6.3 Нэмэлт төсөв	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Залруулсан алдаа	20
4.3 Албан шаардлага	20
4.4 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХНН	Хувь нийлүүлсэн нийгэмлэг



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА Б.ЦЭНГЭЛ ТАНАА

2022.02.24 № 07/313

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	556,154,745.20	373,427,919.47
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	434,440,092.13	98,191,305.65
312	Банканд байгаа бэлэн мөнгө	434,440,092.13	98,191,305.65
3121	Төгрөг	434,440,092.13	98,191,305.65
31214	Бусад төсөл нөөцийн харилцах	434,440,092.13	98,191,305.65
33	АВЛАГА	117,970,073.07	254,170,887.82
33500	Бусад авлага	117,970,073.07	254,170,887.82
33510	Байгууллагаас авах авлага	117,970,073.07	254,170,887.82
35	БАРАА МАТЕРИАЛ	3,744,580.00	21,065,726.00
35400	Хангамжийн материал	3,744,580.00	21,065,726.00
35410	Бичиг хэргийн материал	2,610,680.00	5,135,020.00
35420	Аж ахуйн материал	-	1,243,540.00
35440	Түлш, шатах, тослох материал	-	1,010,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,133,900.00	13,677,166.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,037,822,634.11	3,132,985,306.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,037,822,634.11	3,132,985,306.34
39200	Биет хөрөнгө	2,953,102,234.11	3,048,264,906.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,751,191,680.00	2,751,191,680.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(132,813,067.68)	(199,219,601.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	122,648,620.57	439,341,514.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(46,200,511.87)	(152,203,471.04)
39205	Машин тоног төхөөрөмж (Компьютер)	364,129,969.24	320,126,612.04
39206	Хуримтлагдсан элэгдэл	(181,608,684.81)	(156,242,324.45)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	297,884,779.00	285,026,350.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(222,130,550.34)	(239,755,853.19)
39300	Биет бус хөрөнгө	84,720,400.00	84,720,400.00
39301	Программ хангамж	49,750,000.00	49,750,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	35,960,400.00	35,960,400.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(990,000.00)	(990,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,593,977,379.31	3,506,413,225.81
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	435,372,664.13	110,549,174.55
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	435,372,664.13	110,549,174.55
41300	Өглөг	435,372,664.13	110,549,174.55
41360	Бусад өглөг	435,372,664.13	110,549,174.55
41361	Байгууллагад төлөх өглөг	435,372,664.13	110,549,174.55
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,158,604,715.18	3,395,864,051.26
51	Засгийн газрын оролцоо	3,158,604,715.18	3,395,864,051.26
51101	Засгийн газрын хувь оролцоо	35,655,560.00	35,655,560.00
51101	Өмч /төрийн/	35,655,560.00	35,655,560.00
512	Хуримтлагдсан үр дүн үр дүн	2,724,882,620.23	2,962,141,956.31
51210	Өмнөх үеийн үр дүн	4,624,835,014.93	2,724,882,620.23
51220	Тайлант үеийн үр дүн	(1,899,952,394.70)	237,259,336.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээ	398,066,534.95	398,066,534.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,593,977,379.31	3,506,413,225.81

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	Үйл ажиллагааны орлогын дүн (I)	174,992,607,244.69	214,330,278,807.97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	173,657,881,644.69	213,042,793,312.23
120	Нийтлэг татварын бус орлого	173,212,259,484.69	213,042,258,312.23
120001	Хувьцааны ногдол ашиг	170,552,803,838.40	209,645,728,227.36
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	23,000,000.00	7,197,004.26
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,000,000.00	7,197,004.26
120005	Түрээсийн орлого	2,472,052,275.52	2,650,831,341.77
120009	Бусад орлого	31,813,974.50	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	132,589,396.27	285,465,805.32
121	Хөрөнгийн орлого	445,622,160.00	453,035,933.52
121002	Өмч хувьчлалын орлого	445,622,160.00	453,035,933.52
122	Тусламжийн орлого	-	535,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	535,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,334,725,600.00	1,287,485,495.74
1310	Улсын төвлөрсөн төсвөөс санхүүжих	1,249,725,600.00	1,186,647,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,249,725,600.00	1,186,647,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85,000,000.00	100,837,995.74
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт	85,000,000.00	100,837,995.74
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	174,940,938,159.61	214,087,153,822.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	174,940,938,159.61	214,087,153,822.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,124,509,943.01	1,328,400,582.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	705,650,140.17	846,591,846.99
210101	Үндсэн цалин	516,660,400.00	616,124,039.49
210102	Нэмэгдэл	162,111,350.17	152,028,407.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,878,390.00	78,439,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,118,413.49	87,713,509.71
210201	Тэтгэврийн даатгал	29,021,857.76	52,116,513.33
210202	Тэтгэмжийн даатгал	3,326,890.13	8,693,846.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,605,189.52	6,834,117.31
210204	Ажилгүйдлийн даатгал	651,299.61	1,674,929.11
210205	Эрүүл мэндийн даатгал	6,513,176.47	18,394,103.52
2104	Хангамж бараа материалын зардал	30,272,740.00	39,895,707.39
210401	Бичиг хэрэг	9,786,940.00	9,724,510.00
210402	Тээвэр шатахуун	7,414,300.00	4,345,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,140,400.00	14,646,712.39
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,931,100.00	11,178,885.00
2107	Томилолт зочны зардал	2,978,800.00	-
21702	Дотоод албан томилолт	2,978,800.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	142,529,263.66	145,795,201.00

210801	Бусдаар гүйцэтгүүлэх бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	119,396,147.98	136,883,040.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	730,080.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	297.34
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	120,000.00	-
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	21,513,115.68	7,728,783.00
210807	Газрын төлбөр	-	155,954.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	200,960,585.69	208,404,317.46
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	722,100.00	700,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	200,238,485.69	207,704,317.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	173,816,428,216.60	212,758,753,239.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,373,280.00	5,071,552.00
213204	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	8,269,280.00	5,071,552.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	92,104,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	173,716,054,936.60	212,753,681,687.70
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	245,576,662.68	144,809,665.82
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	173,470,478,273.92	212,608,872,021.88
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	51,669,085.08	243,124,985.71
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,951,621,479.78	5,865,649.63
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,951,621,479.78	5,865,649.63
VI	НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(1,899,952,394.70)	237,259,336.08

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,655,560.00	398,066,534.95	4,624,835,014.93	5,058,557,109.88
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	35,655,560.00	398,066,534.95	4,624,835,014.93	5,058,557,109.88
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,899,952,394.70)	(1,899,952,394.70)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,655,560.00	398,066,534.95	2,724,882,620.23	3,158,604,715.18
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	35,655,560.00	398,066,534.95	2,724,882,620.23	3,158,604,715.18
Тайлант үеийн үр дүн	-	-	237,259,336.08	237,259,336.08
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,655,560.00	398,066,534.95	2,962,141,956.31	3,395,864,051.26

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	174,860,017,848.42	213,903,554,521.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	173,525,292,248.42	212,616,069,026.14
120	Нийтлэг татварын бус орлого	173,079,670,088.42	212,616,069,026.14
120001	Хувьцааны ногдол ашиг	170,552,803,838.40	209,645,728,227.36
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,000,000.00	7,197,004.26
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,000,000.00	7,197,004.26
120005	Түрээсийн орлого	2,472,052,275.52	2,510,107,861.00
120009	Бусад орлого	31,813,974.50	-
121	Хөрөнгийн орлого	445,622,160.00	453,035,933.52
121002	Өмч хувьчлалын орлого	445,622,160.00	453,035,933.52
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,334,725,600.00	1,287,485,495.74
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,249,725,600.00	1,186,647,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,249,725,600.00	1,186,647,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85,000,000.00	100,837,995.74
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	85,000,000.00	100,837,995.74
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР Төсвийн ЗЭЭЛИЙН ДҮН (2)	175,469,422,768.92	214,152,074,808.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	175,469,422,768.92	214,152,074,808.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,652,994,552.32	1,393,321,568.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	705,650,140.17	808,314,062.60
210101	Үндсэн цалин	516,660,400.00	577,968,970.06
210102	Нэмэгдэл	162,111,350.17	152,028,407.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,878,390.00	78,316,685.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,118,413.49	77,820,923.18
210201	Тэтгэврийн даатгал	29,021,857.76	53,460,987.74
210202	Тэтгэмжийн даатгал	3,326,890.13	6,173,983.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,605,189.52	4,858,547.15
210204	Ажилгүйдлийн даатгал	651,299.61	1,181,036.71
210205	Эрүүл мэндийн даатгал	6,513,176.47	12,146,367.72
2104	Хангамж, бараа материалын зардал	31,680,940.00	30,634,870.74
210401	Бичиг хэрэг	8,809,000.00	8,661,850.00
210402	Тээвэр шатахуун	7,414,300.00	5,355,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,140,400.00	7,627,995.74
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,317,240.00	8,989,425.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	85,000,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	85,000,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	2,978,800.00	-
210702	Дотоод албан томилолт	2,978,800.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	143,620,263.66	139,602,925.65
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	121,896,147.98	120,757,020.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	730,680.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	297,344.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	120,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,104,115.68	17,344,699.65

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	641,945,995.00	336,948,786.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	641,223,895.00	336,248,786.48
210902	ХИчээл үйлдвэрлэлийн дадлага	722,100.00	700,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	173,816,428,216.60	212,758,753,239.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,373,280.00	5,071,552.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,269,280.00	5,071,552.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	92,104,000.00	-
2133	Улсын төвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	173,716,054,936.60	212,753,681,687.71
213303	Төвлөрүүлэг шилжүүлэх	245,576,662.68	142,538,165.83
	Төвлөрүүлэх шилжүүлэх нэмэлт		2,271,500.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	173,470,478,273.92	212,608,872,021.88
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(609,404,921.00)	(248,520,286.48)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	87,728,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	87,728,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	87,728,500.00
225106	Биет ба бус хөрөнгө худалдан авсан зардал	-	87,728,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	=	<u>87,728,500.00</u>
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII) = (III)+(VI)+(VII)	(609,404,921.00)	(336,248,786.48)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,043,845,013.13	434,440,092.13
10	Мөнгө, түүний адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	434,440,092.13	98,191,305.65

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл					
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,191,647,500.00	1,051,306,338.43	140,341,161.57	88.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,191,647,500.00	1,051,306,338.43	140,341,161.57	88.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,184,393,900.00	1,046,234,786.43	138,159,113.57	88.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	899,669,800.00	808,314,062.60	91,355,737.40	89.8
210101	Үндсэн цалин	594,724,400.00	577,968,970.06	16,755,429.94	97.2
210102	Нэмэгдэл	202,273,400.00	152,028,407.50	50,244,992.50	75.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	102,672,000.00	78,316,685.04	24,355,314.96	76.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,455,400.00	77,820,923.18	43,634,476.82	64.1
210201	Тэтгэврийн даатгал	85,468,600.00	53,460,987.74	32,007,612.26	62.6
210202	Тэтгэмжийн даатгал	8,996,700.00	6,173,983.86	2,822,716.14	68.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,197,400.00	4,858,547.15	2,338,852.85	67.5
210204	Ажилгүйдлийн даатгал	1,799,300.00	1,181,036.71	618,263.29	65.6
210205	Эрүүл мэндийн даатгал	17,993,400.00	12,146,367.72	5,847,032.28	67.5
2104	Хангамж, бараа материалын зардал	26,216,300.00	26,147,275.00	69,025.00	99.7
210401	Бичиг хэрэг	7,495,000.00	7,432,850.00	62,150.00	99.2
210402	Тээвэр, шатахуун	5,356,900.00	5,355,600.00	1,300.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,369,400.00	4,369,400.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,995,000.00	8,989,425.00	5,575.00	99.9
2107	Томилолт, зочны зардал	2,263,200.00	-	-	0.0
210702	Дотоод албан томилолт	2,263,200.00	-	-	0.0
2107	Томилолт зочны зардал	2,263,200.00	-	2,263,200.00	0.0
21702	Дотоод албан томилолт	2,263,200.00	-	2,263,200.00	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	134,067,100.00	133,252,525.65	814,574.35	99.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	114,721,100.00	114,406,620.00	314,480.00	99.7
210803	Даатгалын үйлчилгээ	1,025,000.00	730,680.00	294,320.00	71.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	297,344.00	2,656.00	99.1
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	120,000.00	-	-	0.0
210805	Тээврийн оношилгоо	120,000.00	1.00	119,999.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,426,000.00	17,344,699.65	81,300.35	99.5
210807	Газрын төлбөр	475,000.00	473,182.00	1,818.00	99.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	722,100.00	700,000.00	22,100.00	96.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	722,100.00	700,000.00	22,100.00	96.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,253,600.00	5,071,552.00	2,182,048.00	69.9
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-	-

213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,253,600.00	5,071,552.00	2,182,048.00	69.9
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,253,600.00	5,071,552.00	2,182,048.00	69.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,191,647,500.00	1,051,306,338.43	140,341,161.57	88.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,186,647,500.00	1,046,306,338.43	140,341,161.57	88.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,186,647,500.00	1,046,306,338.43	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	111	111		100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.0
610001	Төсвийн байгууллага	1	1		100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	55	52		94.5
620001	Удирдах ажилтан	8	8		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	36	34		94.4
620003	Үйлчлэх ажилтан	11	10		90.9
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	55	52		94.5
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	44	42		95.5
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	10		90.9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	100,837,995.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	100,837,995.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	98,566,495.74
2104	Хангамж, бараа материалын зардал	-	4,487,595.74
210401	Бичиг хэрэг	-	1,229,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	3,258,595.74
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	87,728,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	69,151,000.00
210602	Тавилга	-	18,577,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	6,350,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	6,350,400.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,271,500.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,271,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	100,837,995.74
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	100,837,995.74
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	100,837,995.74
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох, анхан шатны баримтын бүрдэл болон батлагдсан төсвийг зориулалтын зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-наас 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хооронд ахлах аудитор Д.Болор-Эрдэнэ, аудитор Д.Эрдэнэчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Аудитын хоёрдугаар газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А-1/140 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Төрийн өмчийн талаар хууль тогтоомж, бодлого, чиглэл, баримт бичгийн төсөл боловсруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулах удирдлага, зохицуулалтаар хангах;
- Төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалахтай холбоотой бүртгэл, тооллого явуулах, төрийн өмчийн бүрэн бүтэн байдал, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн байдалд хяналт тавих;
- Захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээлэл, технологийн хөгжлийг хангах чиг үүргийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2021 оны “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” 190 дүгээр тушаал;
- Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 88, 388 дугаар тогтоол
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/76 дугаар тушаалаар баталсан;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг тооцож ажилласан байна.

Тайлант хугацаанд Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтсээс 27 хуулийн этгээдэд хяналт шалгалтыг хэрэгжүүлж, 11 төсөвт байгууллагад 12,490,700.0 мянган төгрөгийн, 9 хуулийн этгээдэд 1,268,100.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, зөвлөмж хүргүүлэн тухай бүр хяналт тавьж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 214,005,177.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,140,051.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг аудитын явцад дахин хянахад гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 87,564.2 мянган төгрөгөөр буюу 2.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данстууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	434,440.0	98,191.3	(336,248.70)
Авлага	117,970.1	254,170.9	136,200.8

Бараа материал	3,744.6	21,065.7	17,321.1
Үндсэн хөрөнгө	3,037,822.6	3,132,985.3	95,162.7
Нийт хөрөнгө	3,593,977.4	3,506,413.2	(87,564.2)
Өр төлбөр	435,372.7	110,549.2	(324,823.5)
Засгийн газрын хувь оролцоо	3,158,604.7	3,395,864.0	237,259.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,593,977.4	3,506,413.2	(87,564.2)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 98,191.3 мянган төгрөг болж, 336,248.7 мянган төгрөгөөр буурсан нь иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан эд хөрөнгө түрээслүүлэх гэрээний дагуу байршуулсан өмнөх онуудын барьцаа хөрөнгийг чөлөөлснөөс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 254,170.9 мянган төгрөг болж, 136,200.8 мянган төгрөгөөр өссөн нь иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан эд хөрөнгө түрээслүүлэх гэрээний дагуу түрээслэгчдээс авах 152,375.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 21,065.7 мянган төгрөг болж, 17,321.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 13,677.1 мянган төгрөгийн компьютерын дагалдах хэрэгсэл худалдан авсан бүртгэлтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,132,985.3 мянган төгрөг болж, 95,162.7 мянган төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Үндсэн хөрөнгийн орлого:

- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас ТӨБЗГ-ын 2021 оны 162 дугаар тогтоолоор 255,695.0 мянган төгрөгийн автомашин тээврийн хэрэгсэл;
- “Таван толгой дулааны станц” ТӨҮГ -аас ТӨБЗГ-ын 2021 оны 317 дугаар тогтоолоор 6,000.0 мянган төгрөгийн автомашин тээврийн хэрэгсэл;
- Иргэний нисэхийн ерөнхий газраас ТӨБЗГ-ын 2021 оны 361 дүгээр тогтоолоор 65,000.0 мянган төгрөгийн автомашин тээврийн хэрэгсэл;
- Эрчим хүчний яамнаас ТӨБЗГ-ын 2021 оны 421 дүгээр тогтоолоор 29,450.0 мянган төгрөгийн балансын үнэ бүхий автомашин тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлэн хүлээн авч данс бүртгэлд тусгасан.

Үндсэн хөрөнгийн зарлага:

- ТӨБЗГ-ын 2021 оны 726 дугаар тогтоолоор 53 ширхэг 108,292.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг акталж, данснаас хасах шийдвэрийн дагуу бүртгэсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 110,549.2 мянган төгрөг болж, 324,823.5 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээсэлж буй иргэн, аж ахуй нэгж байгууллагын түрээсийн барьцаа хөрөнгө чөлөөлснөөс шалтгаалжээ.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 3,395,864.0 мянган төгрөг болж, 237,259.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ТӨБЗГ-ын тогтоолын дагуу нийт 356,145.0 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авч бүртгэснээс шалтгаалсан байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 39,337,671.5 мянган төгрөгөөр буюу 22.4 хувиар, нийт зардал өмнөх оноос 39,146,215.7 мянган төгрөгөөр буюу 22.3 хувиар тус тус өссөн байна.

Энэ нь хувьцааны ногдол ашиг өмнөх оноос 39,829,998.9 мянга, түрээсийн орлого 178,779.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, улсын төсөвт төвлөрүүлснээс голлон шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,949,545.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,740,245.1 мянган төгрөгөөр бууруулж, төлөвлөгөөг 1,209,300.0 мянган төгрөгөөр баталсан байна. Мөн 2021 оны долоодугаар сард төсвийн тодотголоор 17,652.5 мянган төгрөгөөр бууруулан 1,191,647.5 мянган төгрөгөөр баталж хүргүүлсэн байна.

Тайлант онд 1,191,647.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, мөн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зарцуулагдаагүй үлдэгдэл 140,341.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн нь төсвийг бодитой төлөвлөөгүй байгааг харуулж байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,191,647.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,186,647.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 5,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,186,647.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 5,000.0 мянган төгрөг, нийт 1,191,647.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн, урсгал үйл ажиллагааны зардалд 1,051,306.3 мянган төгрөгийг зарцуулж, 140,341.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,051,306.3 мянган төгрөг буюу 88.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 91,355.7 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 43,634.5 мянга, дотоод албан томилолтын зардлыг 2,263.2 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 2,182.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэлийг 140,341.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь тайлант онд Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж нийт төсвийн зардлаас 11.8 хувийн хэмнэлт гарган ажилласан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70426	Төрийн өмчийг эрхийг хэрэгжүүлэх	1,191,647.5	1,051,306.3	140,341.2	88.2
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,184,393.9	1,046,234.8	135,895.9	88.3
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	7,253.6	5,071.5	2,182.0	69.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд зааснаар Төрийн өмчийн бодлого,

зохицуулалтын газар тайлант онд улсын төсөвт орлого төвлөрүүлэх төлөвлөгөөг 38,008,871.3 мянган төгрөгөөр буюу 115.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 3. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Төрийн өмчид ноогдох хувьцааны ногдол ашиг	173,000,000.0	209,645,728.2	(36,645,728.2)	121.2
Төрийн өмчийн түрээсийн орлого	1,600,000.0	2,510,107.9	(910,107.9)	156.8
Өмч хувьчлалын орлого	-	453,035.2	(453,035.2)	-
Нийт дүн	184,600,000.0	212,608,871.3	(38,008,871.3)	115.2

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн дагуу төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн орлогыг 209,645,728.2 мянган төгрөг буюу 121.2 хувиар, төрийн өмчийн түрээсийн орлогыг 2,510,107.9 мянган төгрөг буюу 156.8 хувиар орлогын төлөвлөгөөг биелүүлснээс гадна дуудлага худалдааны орлого 453,035.2 мянган төгрөг, нийт 212,608,871.3 мянган төгрөгийн татварын бус орлогыг бүрдүүлж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Сангийн сайдын 2021 оны 217 дугаар тушаалаар төсвийн байгууллагын үйл ажиллагааны давсан орлогоос 100,838.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, өр төлбөр үүссэн бараа, ажил үйлчилгээний зардалд 4,487.6 мянга, эд хогшил урсгал засварын зардалд 87,728.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 6,350.4 мянга, нийт 98,566.5 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 2,271.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээний хэрэгжилт 91.7 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 88.2 хувийн биелэлттэй байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд өөрийн байргүй тул Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаанд нийт 78,567.4 мянган төгрөгийн байр ашиглалтын төлбөр шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх субъектүүд нь Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг мөрдөж ажилладаггүй, чиглэлийн яам төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудад хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлснээр бодлогын удирдамжаар хангах, мониторингийн хяналт тавих чиг үүрэг нь эрх зүйн хувьд зөрчилдөж, адил тэгш үйлчлэх үндсэн зарчим алдагдах эрсдэлтэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 190,898.0 мянган төгрөгийн 4 гүйлгээ, зарлагын 19,642.6 мянган төгрөгийн 2 ажил гүйлгээг ил тод байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “*мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх*”, 6 дугаар зүйлийн 6.4.4-д “*таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг*”, мөн 6.4.5-д “*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*” гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулж, ил тод байдлыг ханган ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны хуульд заасан мэдээлэл байршуулаагүй нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 228 дугаар тогтоолоор төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай харилцан тохиролцож тогтоосон байх боловч уг тогтоолд 677 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж, Төрийн банк ХХК, Эрдэнэс Монгол ХХК, УБ төмөр зам ХНН-ийн улсын төсөвт ногдол ашиг төвлөрүүлэх хугацааг 2022 оны 2 дугаар улиралд багтаан төвлөрүүлэхээр хойшлуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3-т “*төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох*” гэж заасантай нийцэхгүй байх бөгөөд баталсан хуваарьт өөрчлөлт оруулах бүрэн эрх тус газарт энэ хуулиар олгогдоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг төвлөрүүлэх тогтоолд өөрчлөлт оруулахгүй, тогтоосон хугацаанд бүрэн төвлөрүүлэх, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2.Улсын төсөвт 2021 онд төвлөрүүлсэн ногдол ашгийн орлогын 98.2 хувийг ТӨБЗГ-аас хувьцаа эзэмшигчдийн эрхийг 100 хувь хэрэгжүүлдэг төрийн өмчит хуулийн этгээдээс төвлөрүүлсэн байна. Тус газраас бусад /Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрчим хүчний яам, Эрдэнэс Монгол ХХК/ хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид нь нийт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын 60-70 хувьд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа ч төвлөрүүлэх ногдол ашгийн орлогын 1.8 хувийг бүрдүүлж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 “*төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах*

ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр хувьцаа эзэмшигчийн эрхийг нэгдмэл удирдлагаар хангах, компанийн засаглал, үр ашгийг сайжруулах, ногдол ашиг төвлөрүүлэх тооцооллыг нарийвчлан тогтоох албан шаардлага хүргүүлэв.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4,116,128.2 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 2,958,898.3 төгрөгийн алдаа, зөрчлийг хэрэгжүүлж, акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 89.7 хувьтай байна.

Хүснэгт 4. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт				Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	4	3,737,503.0	2	2,580,273.1	2	1,157,229.9	69.0
Албан шаардлага	3	288,878.0	3	288,878.0	-	-	100.0
Зөвлөмж	3	89,747.2	3	89,747.2	-	-	100.0
Нийт дүн	10	4,116,128.2	8	2,958,898.3	2	1,157,229.90	89.7

Улаанбаатар төмөр зам ХНН-ийн 1,137,200.0 мянга, Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨҮГ-ын 19,216.7 мянган төгрөгийн төлбөрийн актыг тодорхой шалтгааны улмаас улсын төсөвт төвлөрүүлээгүй тул хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлээ.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

УИХ-ын 2021 оны “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 88 дугаар тогтоолын 1.1-д “Төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээдүүд жилийн эцсийн санхүүгийн тайлангаар гарсан цэвэр ашгийн 50 хувь болон төрийн эзэмшилд хамаарах эздийн өмчийн 1 хувьтай тэнцэх дүнгийн аль өндөр хэмжээгээр ногдол ашиг тооцон хуваарилж, төсөвт төвлөрүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авахыг чиглэл болгон ажиллах” гэж заасан тул хувьцааны ногдол ашгийн тооцоолол, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, хэрэгжилттэй холбоотой авлага, өр төлбөрийг санхүүгийн тайланд хэрхэн тусгаж баталгаажуулах нь анхаарал татахуйц байсан тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 215,112,804,2 мянган төгрөгийн 18 алдаа зөрчил илэрснээс, 213,476,074.4 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 1,441,938.3 мянган төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 194,791.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 7 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 1,636,729.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин 2,140,051.8 мянган төгрөгөөс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлангийн орлого, зарлагын 213,188,496.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- ТӨБЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ны 726 дугаар тогтоолын дагуу 108,292.8 мянган төгрөгийн акталсан үндсэн хөрөнгийг данснаас хасаж бүртгээгүй;
- Бараа материалын шинжтэй 13,677.1 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан;
- Авлагын тодруулга тайланд үлдэгдлийг 150,200.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;
- Түрээсийн барьцаа хөрөнгийн өглөг дансанд бүртгэлтэй үлдэгдлээс түрээсийн орлогод суутган тооцуулж, тооцоо нийлсэн боловч 15,407.6 төгрөгийн түрээсийн орлогыг улсын төсөвт дутуу төвлөрүүлснийг аудитын явцад Үндэсний аудитын газрын 01/A170067 дугаар төлбөрийн акт тогтоож, 100900008354 тоот дансанд 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдөр төвлөрүүлсэн байна.

4.3 Албан шаардлага

1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн “Төрийн өөрийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын дагуу иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан эд хөрөнгө түрээслүүлэх гэрээний дагуу улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн 152,375.4 мянган төгрөгийн орлогыг хугацаандаа төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “*өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэж заасантай нийцэхгүй эрх үүрэг ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн орлогыг гэрээнд заасан хугацаанд улсын төсөвт төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Үндэсний аудитын газраас өмнөх онд Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨҮГ-т холбогдох 19,216.7 мянган төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлэх төлбөрийн актыг хэрэгжүүлж ажиллаагүй нь Төрийн аудитын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 “*Засгийн газар төрийн аудитын байгууллагаас Засгийн газрын харьяа захиргааны байгууллагад өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг хэрэгжүүлэхэд төрийн аудитын байгууллагатай хамтран ажиллана*” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу төвлөрүүлсэн ногдол ашгийг улсын төсөвт бүрэн төвлөрүүлэх, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3. Хөдөө аж ахуйн давхар даатгал ХХК-ийн 2017, 2018 оны цэвэр ашгаас тооцсон нийт 1,264,346.3 мянга, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв ТӨҮГ-ийн 6,000.0 мянган төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д “*Улсын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ*”, 23.5.1-т “*Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1 зааснаас бусад төрийн өмчид ногдох*

хувьцааны ногдол ашиг”, Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 117 дугаар тогтоол, 2018 оны 322 дугаар тогтоолтой тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу төвлөрүүлсэн ногдол ашгийг улсын төсөвт бүрэн төвлөрүүлэх, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

БНХАУ-ын Засгийн газраас МУЗГ-т өгсөн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр баригдсан 5235 м.кв талбайтай, 6 давхар, 27 өрөө бүхий барилгыг Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим ТББ-д зөвхөн ашиглалтын зардал төлөх нөхцөлтэй гэрээ байгуулан ашиглуулж байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2001 оны "Төрийн өөрийн хөрөнгө түрээслүүлэх журам" 134 дүгээр тогтоолын 3-т "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээсээр эзэмшүүлэх зорилго нь төрийн өмчийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ" ТӨБЗГ-ын 2020 оны 49 дүгээр тогтоолын 8-д "төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх, төлбөрийн хэмжээг 1 жилд байгуулах элэгдлийн хэмжээнээс багагүй байхаар тооцон эд хөрөнгийн ашиглалтын хугацаа, ашиглалтын нөхцөл, түрээсийг тогтоож, гэрээнд тусган ТӨБЗГ-аар баталгаажуулна" гэж заасантай тус тус нийцүүлэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим ТББ-тай түрээсийн гэрээ байгуулж, хөрөнгийн ашиглалтыг сайжруулж, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэх

1.2. Илрүүлэлт:

Балансаас балансд шилжиж ирсэн үлдэх өртөггүй тээврийн хэрэгслийг тогтоол шийдвэргүй, дахин үнэлгээ хийж 29,450.0 мянган төгрөгөөр бүртгэлд тусгасан нь ТӨБЗГ-ын 2019 оны 277 дугаар тогтоолын 7.1-т "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой хөрөнгийн судалгаа гаргаж, тогтоол шийдвэрийн дагуу хөрөнгөд дахин үнэлгээ хийх, бүртгэл тайланд тусгах

1.3. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой 120,890.2 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 277 дугаар тогтоолын 7.1-т "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой хөрөнгийн судалгаа гаргаж, тогтоол шийдвэрийн дагуу хөрөнгөд дахин үнэлгээ хийх, бүртгэл тайланд тусгах

1.4. Илрүүлэлт:

Ашиглах хугацаа дуусаагүй 16 нэр төрлийн 36,160.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийг илүү тооцож, санхүүгийн тайланд зөрүүтэй бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт,

эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалд тооцоолол хийж, залруулан бүртгэх, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж тайлагнах

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу 1,272.6 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэл хангасан ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгаж, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх

2.3. Илрүүлэлт:

Шуудан холбооны зардал 7,018.7 мянган төгрөгийг мэдээлэл, технологи үйлчилгээний зардлаас зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалд заасантай нийцэхгүй байна. нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулах

3. Тайлагналтай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

НБББББ-т түрээсийн орлого, ногдол ашгийн орлого, дуудлага худалдааны орлогыг бүртгэлд хэрхэн тусгаж тайлагнах талаар тодорхой тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн болон ногдол ашгийн орлогын бүртгэлийг байгууллагын онцлогт тохируулан холбогдох стандартын дагуу НБББББ-д тусгаж, мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэр, аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
				Тоо	Дүн	Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
						Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар АХГ-2022/151/НА-СТА-ТШЗ	Төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулгын тайлангийн орлого, зарлагын дүнгээр залруулсан.	Санхүүгийн тайланд залруулах	1	213,188,496.9	1	213,188,496.9						
2		ТӨБЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ны 726 дугаар тогтоолын дагуу акталсан үндсэн хөрөнгийг данснаас хасаж бүртгээгүй байна.	Санхүүгийн тайланд залруулах	1	108,292.8	1	108,292.8						
3		Бараа материалын шинжтэй хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна.	Санхүүгийн тайланд залруулах	1	13,677.1	1	13,677.1						
4		Авлагын тодруулга тайланд авлагын үлдэгдлийг зөрүүтэй бүртгэсэн.	Санхүүгийн тайланд залруулах	1	150,200.0	1	150,200.0						
5		Түрээсийн барьцаа хөрөнгийн өглөг дансанд бүртгэлтэй үлдэгдлээс түрээсийн орлогод суутган тооцуулж, тооцоо нийлсэн боловч түрээсийн орлогыг улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.	Санхүүгийн тайланд залруулах	1	15,407.6	1	15,407.6						
6		"Төрийн өөрийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-ын дагуу иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан эд хөрөнгийн эд хөрөнгө түрээслүүлэх гэрээний дагуу улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогыг тогтоосон хугацаанд нь төвлөрүүлээгүй, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байна.	Албан шаардлага хүргүүлэх	1	152,375.3					1	152,375.3		
7		Үндэсний аудитын газраас Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨҮГ-ын 2019 оны цэвэр ашгаас тооцсон ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр тогтоосон төлбөрийн актыг барагдуулаагүй байна.	Албан шаардлага хүргүүлэх	1	19,216.7					1	19,216.7		
8		ТӨБЗГ-ын 2017 оны 117 дугаар тогтоолоор баталсан "ХАА-н давхар даатгал" ХХК-ийн 1,264,300.0 мянган төгрөгийн, "ХААҮШУОНТ" ТӨҮГ-ын 6,000.0 мянган төгрөгийн цэвэр ашгаас тооцсон ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	Албан шаардлага хүргүүлэх	1	1,270,346.3					1	1,270,346.3		
9		Шатахууны зардлын замын хуудсанд тооцоо хийж баталгаажуулаагүй, шатахууны талон дутуу зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгасан.	Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах зөвлөмж өгөх	1	1,272.6							1	1,272.6
10		Мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлаас шуудан холбооны зардал төлж, төсвийг ангилал	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу	1	7,018.7							1	7,018.7

**Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

		хооронд зөвшөөрөлгүй шилжүүлэн зарцуулсан байна.	бүртгэх зөвлөмж өгөх										
11		Балансаас балансад шилжиж ирсэн үлдэх өртөггүй тээврийн хэрэгслийг ТӨБЗГ-ын шийдвэргүй, дахин үнэлгээ хийж 29,450.0 мянган төгрөгөөр бүртгэлд тусгасан байна.	Дахин үнэлэнгээ хийх, зөвлөмж өгөх	1	29,450.0						1	29,450.0	
12		Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 120,890.2 мянган төгрөгийн хөрөнгийг ашиглах болон дахин үнэлүүлэн, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.	Дахин үнэлэнгээ хийх, зөвлөмж өгөх	1	120,890.2						1	120,890.2	
13		Ашиглах хугацаа нь дуусаагүй 16 нэр төрлийн 36,160.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийг илүү тооцож, санхүүгийн тайланд зөрүүтэй бүртгэсэн байна.	Элэгдлийн зардлыг залруулж бүртгэх зөвлөмж өгөх	1	36,160.0						1	36,160.0	
14		БНХАУ-ын засгийн газраас МУЗГ-т өгсөн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр баригдсан 5235 м.кв талбайтай, 6 давхар, 27 өрөө бүхий барилгыг тухайн байгууллагын хөрөнгөд 2019 онд бүртгэж, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим ТББ-д үнэ төлбөргүйгээр, 2021 оноос 3 жилийн хугацаатай зөвхөн ашиглалтын зардлаа төлөх нөхцөлөөр гэрээ байгуулан ашиглуулж байна.	Түрээсийн гэрээ байгуулах зөвлөмж өгөх	1							1	-	
15		НБББББ-т түрээсийн орлого, ногдол ашгийн орлого, дуудлага худалдааны орлогыг бүртгэлд хэрхэн тусгаж тайлагнах талаар тодорхой тусгаагүй, аппаратын үйл ажиллагааны орлого зарлагын гүйлгээний журнал, ерөнхий дэвтэртэй хамт нэгтгэгдэн тайлагнаснаар санхүүгийн тайланг буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй байна.	НБББББ-д орлогын бүртгэлийг тусгах зөвлөмж	1	-						1	-	
ДҮН				15	215,112,804.2	5	213,476,074.4	-	-	3	1,441,938.3	7	194,791.5
16	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар АХГ-2022/151/НА-СТА-ТШЗ	ТӨБЗГ-ын 2021 оны 677 дугаар тогтоолоор Төрийн банк ХХК, Эрдэнэс Монгол ХХК, УБ төмөр зам ХНН-ийн 2020 оны цэвэр ашгаас тооцсон ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлэх хугацааг 2022 оны 2 дугаар улиралд багтаан төвлөрүүлэхээр хойшлуулсан байна	Албан шаардлага хүргүүлэх	1	-								
17		Тус байгууллага нь 2021 оны 2,3 дугаар саруудад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 190,898.0 мянган төгрөгийн 4 гүйлгээ, зарлагын 19,642.6 мянган төгрөгийн 2 гүйлгээг ил тод байршуулаагүй байна.	Албан шаардлага хүргүүлэх	1	-								

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

18	Шилэн дансанд 123 мэдээлэл байршуулахаас 82 мэдээллийг хугацаандаа, 41 мэдээллийг хугацаа хоцроож, 89,592.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг ил тод мэдээлж байршуулаагүй байна.	Албан шаардлага хүргүүлэх	1	-							-		
	ДҮН		3	-	-	-	-	-	-	-	-	-	-
	НИЙТ ДҮН		11	215,112,804.2	5	213,476,074.4	-	-	3	1,441,938.3	7	194,791.5	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 24

№ 01/А0170067

Улаанбаатар хот

АХГ-2022/151/НА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн түрээсийн дансанд бүртгэлтэй барьцаа хөрөнгийн үлдэгдлээс түрээсийн орлогыг суутган тооцож, тооцоо нийлсэн боловч 15,407,678.00 /арван таван сая дөрвөн зуун долоон мянга зургаан зуун далан найман/ төгрөгийн түрээсийн орлогыг улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дутуу төвлөрүүлсэн 15,407,678.00 /арван таван сая дөрвөн зуун долоон мянга зургаан зуун далан найман/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх, актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, ерөнхий нягтлан бодогч Ц.Гантуяа нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ
Д.ЭРДЭНЭЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 62/А0160064
АХГ-2022/151/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн "Төрийн өөрийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-ын дагуу иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан эд хөрөнгө түрээслүүлэх гэрээний дагуу улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн 152,375,360.00 төгрөгийн орлогыг хугацаандаа төвлөрүүлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн 152,375,360.00 /нэг зуун тавин хоёр сая гурван зуун далан таван мянга гурван зуун жаран/ төгрөгийг хугацаанд нь төвлөрүүлж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, ерөнхий нягтлан бодогч Ц.Гантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ
Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

10.10.10.20\Bichig_Kherag\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-21.Docx

001080085



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 08 дугаар сарын 25 № 63/АД160067
АХГ-2022/151/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндэсний аудитын газраас 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨҮГ-т холбогдох 19,216,753.00 төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлээгүй зөрчилд тогтоосон төлбөрийн актын хэрэгжилтийг биелүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 "Засгийн газар төрийн аудитын байгууллагаас Засгийн газрын харьяа захиргааны байгууллагад өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг хэрэгжүүлэхэд төрийн аудитын байгууллагатай хамтран ажиллана" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨҮГ-ийн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, ерөнхий нягтлан бодогч Ц.Гантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Газар-19.Docx

001080080



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 64/АД160069
АХГ-2022/151/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 190,898,000.00 төгрөгийн 4 гүйлгээ, зарлагын 19,642,600.00 төгрөгийн 2 гүйлгээг ил тод байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4 "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг хангаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, ерөнхий нягтлан бодогч Ц.Гантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ
Д.ЭРДЭНЭЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 65/АД/60069
АХГ-2022/151/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөө аж ахуйн давхар даатгал ХХК нь 2017 оны цэвэр ашгаас тооцсон ногдол ашиг 832,587,450.00 төгрөгийн, 2018 оны цэвэр ашгаас тооцсон ногдол ашиг 431,758,830.00 төгрөгийн буюу нийт 1,264,346,280.00 төгрөгийн, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв ТӨҮГ нь 6,000,000.00 төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 "Улсын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ", 23.5.1 "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1 зааснаас бусад төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг", Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг, мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 117 дугаар тогтоол, 2018 оны 322 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нэр бүхий хуулийн этгээдүүдийн дутуу төвлөрүүлсэн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлж, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, ерөнхий нягтлан бодогч Ц.Гантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ
Д.ЭРДЭНЭЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 66/АД160069
АХТ-2022/151/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 228 дугаар тогтоолоор төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай харилцан тохиролцож тогтоосон байх боловч уг тогтоолд 677 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж, Төрийн банк ХХК, Эрдэнэс Монгол ХХК, УБ төмөр зам ХНН-ийн улсын төсөвт ногдол ашиг төвлөрүүлэх хугацааг 2022 оны 2 дугаар улиралд багтаан төвлөрүүлэхээр хойшлуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3-т “төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох” гэж заасантай нийцэхгүй байх бөгөөд баталсан хуваарьт өөрчлөлт оруулах бүрэн эрх Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт энэ хуулиар олгогдоогүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Захиргааны ерөнхий хуулийн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг төвлөрүүлэх төлөвлөгөөнд өөрчлөлт оруулахгүй байх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, ерөнхий нягтлан бодогч Ц.Гантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ
Д.ЭРДЭНЭЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 135/А0160064

Улаанбаатар хот

АХГ-2022/157/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсөвт 2021 онд төвлөрүүлсэн ногдол ашгийн орлогын 98.2 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хувьцаа эзэмшигчдийн эрхийг 100 хувь хэрэгжүүлдэг төрийн өмчит хуулийн этгээдээс төвлөрүүлсэн байна. Тус газраас бусад /Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрчим хүчний яам, Эрдэнэс Монгол ХХК/ хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид нь нийт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын 60-70 хувьд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа ч төвлөрүүлэх ногдол ашгийн орлогын 1.8 хувийг бүрдүүлж байгаа нь хангалтгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 "төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1.5-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр хувьцаа эзэмшигчийн эрхийг нэгдмэл удирдлагаар хангаж, компанийн засаглал үр ашгийг сайжруулж, санхүү, төсвийн сахилга бат, хөрөнгө оруулалт, хөрөнгийн менежментийг оновчтой тодорхойлох;
2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс ногдол ашиг төвлөрүүлэх тооцооллыг нарийвчлан тогтоож, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллан, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, ерөнхий нягтлан бодогч Ц.Гантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ
Д.ЭРДЭНЭЧИМЭГ